

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com
--	---

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадзад сум, Өмнөговь аймаг, 46003
Утас: (976) 7653 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: info@ovai.audit.gov.mn

0009.08.17 № 41

төвий _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АЛБАН БУС
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Н.АЛГИРМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн албан бус насан туршийн боловсролын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/омчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн албан бус насан туршийн боловсролын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн байгууллага, албан хаагчдыг насан туршийн боловсролын чиглэлийн мэдээллээр хангах зорилгоор и-оффис сүлжээнд байршуулдаг байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь аймгийн боловсролын газарт ирсэн нэхэмжлэл, татварын цахим системд шилсэн төлбөрийн баримыг үндэслэн дулаан цахилгааны төлбөрийг төлж байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

016000055

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж томилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

(сая төгрөгөөр)		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	14.0	15.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	92.4	71.3
Нийт хөрөнгийн дүн	106.4	86.2
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	106.4	86.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	106.4	86.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	148.3	200.6
Үйл ажиллагааны зардлын дүн	166.8	220.8
Үйл ажиллагааны үр дүн	(18.5)	(20.2)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	(18.5)	(20.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Засгийн газрын оруулсан капитал	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
Хуримтлагдсан үр дүн	96.8	86.2
Эцсийн үлдэгдэл	96.8	86.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	148.3	200.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	147.9	199.5
Үйл ажиллагааны ЦМГ	0.4	1.2
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.4	1.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	186.0	166.5
Урсгал зардал	186.0	166.5
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	186.0	167.6
Улсын төсвөөс санхүүжих	136.1	136.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	49.9	30.8
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1.2

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илэрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илэрээгүй								
Дүн								
Нийт дүн								

